



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/120

Зуунмод

Өвс, тэжээл хуваарилах тухай

Аймгийн хэмжээнд 14 сум зудын эрсдэлийн түвшин их, 13 сум зудын эрсдэлийн түвшин дунд зэрэглэлтэй өвөлжиж, хаврын улиралтай золгон зарим сумдад мал идэх өвсгүй, цасанд дарагдсанаас малын идэш тэжээл хомсдон хээл хаях, ядарч доройтох, сульдах үзэгдэл ажиглагдаж байгаа тул мал сүргийг байгалийн болзошгүй бэрхшээлээс хохирол багатай авч гарах зорилгоор Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аюулгүйн нөөцөд байгаа өвс, тэжээлийг сумдад хуваарилсан хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарилагдсан өвс, тэжээлийг шуурхай татан авч, хөрөнгийг аймгийн Мал хамгаалах сангийн дансанд төвлөрүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Сумдад олгосон өвс, тэжээлийг хуваарийн дагуу санхүүгийн анхан шатны баримт үйлдэн хүлээлгэн өгч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Гантулга)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

АЙМГИЙН АЮУЛГҮЙН НӨӨЦӨӨС СУМДАД ХУВААРИЛАГДСАН ӨВС, ТЭЖЭЭЛ

№	Сумын нэр	Өвс /боодол/	Нэгж үнэ /төг/	Үнэ /төг/	Өвс /боодол/	Нэгж үнэ /төг/	Үнэ /төг/	Тэжээл /шуудай/	Тэжээлийн үнэ/төг/	Нийт үнэ /төг/
1	Алтанбулаг	340	11500	3910000	80	10000	800000	50	875000	5585000
2	Аргалант	240		2760000	60		600000	40	600000	3960000
3	Архуст	240		2760000	80		800000	40	600000	4160000
4	Батсүмбэр	240		2760000	60		600000	40	600000	3960000
5	Баян	440		5060000	80		800000	50	875000	6735000
6	Баяндэлгэр	440		5060000	60		600000	40	600000	6260000
7	Баянжаргалан	440		5060000	80		800000	50	875000	6735000
8	Баян-Өнжүүл	540		6210000	80		800000	50	875000	7885000
9	Баянхангай	240		2760000	60		600000	40	600000	3960000
10	Баянцагаан	540		6210000	80		800000	50	750000	7760000
11	Баянцогт	240		2760000	60		600000	40	600000	3960000
12	Баянчандмань	240		2760000	60		600000	40	600000	3960000
13	Борнуур	240		2760000	60		600000	40	600000	3960000
14	Бүрэн	540		6210000	80		800000	50	875000	7885000
15	Дэлгэрхаан	540		6210000	80		800000	50	875000	7885000
16	Жаргалант	240		2760000	60		600000	40	600000	3960000
17	Заамар	440		5060000	60		600000	40	600000	6260000
18	Лүн	540		6210000	80		800000	50	750000	7760000
19	Мөнгөнморьт	240		2760000	60		600000	40	600000	3960000
20	Өндөрширээт	440		5060000	60		600000	50	875000	6535000
21	Сэргэлэн	540		6210000	80		800000	50	750000	7760000
22	Сүмбэр	240		2760000	60		600000	40	600000	3960000
23	Угтаалцайдам	340		3910000	60		600000	40	600000	5110000
24	Цээл	340		3910000	60		600000	40	600000	5110000
25	Эрдэнэ	440		5060000	80		800000	50	875000	6735000
26	Эрдэнэсант	440		5060000	80		800000	50	750000	6610000
27	Зуунмод	240		2760000	60		600000	40	600000	3960000
	Дүн	9980		114,770,000	1860		18,600,000	1200	19,000,000	152,370,000